



## ЯВГАН ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖИЙН АЖИЛ (24 ДҮГЭЭР ХОРОО)-ЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

### Ажлын цар хэмжээ:

Энэхүү ажил нь иргэдэд аюулгүй, тохилог орчинд амьдрах, ажиллах таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилготой.

1	Төсөл боловсруулах үндэслэл	- Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар тогтоол.
2	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	- Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Яармагийн гүүр орчим.
3	Зориулалт хүчин чадал	- Яармагийн гүүрний явган хүний замыг Эко зурвас буюу тус гүүрний зүүн хойно байрлах унадаг дугуйн болон явган хүний замтай холбох ажил. Хүчин чадал төслөөр.
4	Одоогийн байдал	- Одоо явган хүний зам тасалдсан, сул шороон хөрстэй.
5	Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалагч гүйцэтгэгч талуудын хооронд байгуулсан гэрээний хугацааг үндэслэл болгоно.
6	Төслийн захиалагч	- Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар
7	Төсөл гүйцэтгэх үе шат	- Талбайн судалгаа, хэмжилтийг илүү дэлгэрэнгүй хийж, Яармагийн гүүрний явган хүний замыг Эко зурвас буюу тус гүүрний зүүн хойно байрлах унадаг дугуйн болон явган хүний замтай холбох шийдлийг боловсруулж, захиалагч байгууллагатай зөвшилцөн батлуулах. - Нийслэлийн Замын хөгжлийн газар болон бусад мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөх. - Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. (магадлал хийгдсэн байх). - Төсөөт өртөг (магадлал хийгдсэн байх).
8	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<b>Явган зам, талбай:</b> - Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах ерөнхий шаардлага UCS 0901B.

26.0

		<ul style="list-style-type: none"> <li>- Явган замыг 1,8 метрээс дээш өргөнтэйгээр төлөвлөх.</li> </ul>
9	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><b><u>Монгол Улсын хуулиуд</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот байгуулалтын тухай хууль</li> <li>- Авто замын тухай хууль</li> <li>- Газрын тухай хууль</li> <li>- Усны тухай хууль</li> <li>- Бусад холбогдох хууль</li> </ul> <p><b><u>Норм, нормативууд:</u></b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хот, тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм /БНБД30-01-04/</li> <li>- Барилгын орчны тохижилтын ажлын норм ба дүрэм /БНБД 3.01-06-90/</li> <li>- Барилга байгууламжийн зураг төсөв боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм</li> <li>- Бусад холбогдох норм, дүрэм</li> </ul>
10	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> <li>- Гадаргуугийн ус зайлцуулах шийдлийг орчны байгууламжуутдай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.</li> </ul>
11	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> <li>- Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.</li> </ul>
12	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага UCS 0301B стандартыг мөрдөх.</li> <li>- Улаанбаатар хотын “Нэг хот, Нэг стандарт”-ын эмхэтгэл болох UCS стандартуудыг мөрдөж ажиллах.</li> </ul>

ХЯНАСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Л.ОТГОНБАЯР

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

*О.МӨНГӨНШАГАЙ*

Хан-Уул дүүргийн 24 дүгээр хороо, Яармагийн гүүр орчим явган хүний зам.

